

**НҮБ-ЫН ХХААБ-ЫН “ОРГАНИК ХАА-Г ДЭМЖИХ”
ТСР MON/3503ТӨСЛИЙН 2014-2016 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
(2016 оны жилийн эцсийн байдлаар)**

№	Хөтөлбөр/ төслийн агуулга	Гүйцэтгэл			
1	НҮБ-ын ХХААБ, МУ-ын Засгийн газрын хамтарсан “Органик ХАА-г дэмжих” ТСР/MON/3503 техник туслалцааны төсөл	Төслийн зорилго: Органик буюу эко-фермийн үйлдвэрлэлийн талаар мэдлэг олгож, эрх зүйн чадамжийг нэмэгдүүлж, төсөлд оролцогч талуудын уялдааг ханган, тогтвортой хөгжлийн чадавхийг сайжруулах.			
2	Санхүүгийн эх үүсвэр	Буцалтгүй тусламж			
3	Хэрэгжүүлэгч байгууллага/Хэрэгжих хугацаа	Гол хэрэгжүүлэгч байгууллага: НҮБ-ын ХХААБ 2014 оны 9 дүгээр сар - 2016 оны 11 дүгээр сар. 2017 оны 6 дугаар сар хүртэл сунгасан.			
4	Төсөл, хөтөлбөрийн үр дүн	Төслийн гол үр дүн: Орон нутгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, бизнесийг дэмжих Үр дүн 1: Монголын байгальд ээлтэй органик аж ахуйн цогц судалгаа хийсэн байна. Үр дүн 2: Органик ХАА-г дэмжих, чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор Үндэсний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлсэн байна. Үр дүн 3: Төсөлд оролцогч талуудын мэдлэг дээшилж, органик фермийн аж ахуй байгуулагдан, органик бүтээгдэхүүний маркетинг сурталчилгаа хийгдсэн байна. Үр дүн 4: Олон улсын хэмжээнд баталгаажих боломжтой “Монгол органик хүнс”-ний брэндийг бий болгоно.			
5	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)		352,000 ам.доллар	
		Үүнд:	Төсөв (он)	Гүйцэтгэл	Хувь
		Зардал			
Нийт зардал					
6	Төсөл, хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагаа:	Үйл ажиллагааны биелэлт:			
<i>1-р үр дүн: Монголын байгальд ээлтэй фермийн аж ахуйн болон органик хөдөө аж ахуйн талаарх цогц судалгаа хийсэн байна.</i>					
7	<i>Үйл ажиллагаа 1.1.</i> Байгальд ээлтэй, органик хөдөө аж ахуйн өнөөгийн байдал болон зах зээлийн нөөц бололцооны талаар дэлгэрэнгүй судалгааг Монголын Улсын ¹ болон олон улсын ² зах зээлийг хамруулан хийнэ. Судалгааны хүрээнд байгаль орчинд ээлтэй агро технологи болон органик фермерийн аж ахуй эрхлэх боломжийг тодруулна. Мөн дотоодын бүртгэлийн тусгай систем (импортолж байгаа орныхоо дүрэм журам, бүртгэлийн шаардлагад тулгуурласан олон улсын тодорхой систем байдаг)-ийг байгуулах талаарх саналыг зөвлөмж Монгол Улсын Засгийн газарт гаргана.	1.Олон улсын зах зээлийн судалгааны хүрээнд: БНХАУ, Япон, БНСУ-ын органик ХАА-н өнөөгийн байдал, зах зээл, хөгжлийн хандлагыг судлан, өөрийн орны нөхцөлтэй харьцуулан дүгнэлт гаргаж, хэрэгжүүлэх боломжтой үйл ажиллагааны талаар санал боловсруулсан. 2.Эх орны байгальд ээлтэй, газар тариалангийн аж ахуйн өнөөгийн байдлын талаарх судалгааны хүрээнд: “Монголын байгальд ээлтэй, органик фермийн өнөөгийн байдлын үнэлгээ, зах зээлийн нөөц бололцооны цогц судалгаа”-г баримтын болон анхдагч эх үүсвэрийн аргаар явуулж, 2 үе шаттайгаар гүйцэтгэсэн. I шатанд тандалт, II шатанд үнэлгээ хийсэн. Судалгаанд нийт 170 гаруй малчин, 106 аж ахуйн нэгж, өрх, 2331 хэрэглэгч хамрагдсан. 3.Зах зээлийн судалгааны хүрээнд: Хэрэглэгчийн судалгааг Нийслэлийн 6 дүүргийн 2331 хүнийг хамруулан гүйцэтгэсэн. Эх орны газар тариалангийн бүтээгдэхүүн төмс, хүнсний ногоо, жимс-жимсгэнэ болон зөгийн балны дотоодын үйлдвэрлэл, импорт, экспортын хэмжээг баримтын судалгаагаар гаргаж, хэрэгцээг Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооноос гаргасан аргачлалын дагуу тооцсон. Судалгааны дүнд үндэслэн гадаад болон дотоод зах зээлд гаргах бүтээгдэхүүний жагсаалт гаргаж, мэргэжлийн холбоодтой уулзалт зохион байгуулан тэдгээрийн санал, үйлдвэрлэгчдийн өөрсдийн хүсэлт, үйлдвэрлэгчдээс өөрийн бүтээгдэхүүнийг экспортонд гаргах зорилгоор өмнө хийж гүйцэтгэсэн судалгаа, түүний үр дүн, хүсэлт гаргагчдаас үйлдвэрлэлийн явцад учирч болох эрсдлийг даах чадвар, эцсийн үр дүнг үзэх тууштай байдал зэрэгт үндэслэн чацаргана, зөгийн бал, төмс үйлдвэрлэгч 4			

		компанийг загвар органик аж ахуй болгохоор сонгон, гэрээ байгуулан ажилласан. 2016 оны 4 сарын УИХ-ын чуулганаар хэлэлцэж, баталсан Органик хүнсний тухай хуульд мэдээллийн сан бүрдүүлэх тухай 15 заалт тусгагдсан бөгөөд органик хүнсний хяналт, удирдлагын мэдээллийн системийн програм хангамжийг боловсруулах зөвлөх үйлчилгээний тендерийн баримт бичгийг боловсруулан, Үнэлгээний хороонд хэлэлцүүлж байна. <p style="text-align: right;">ХШҮ- 50%</p>
8	Үйл ажиллагаа 1.2. Судалгааны үр дүнгийн талаар оролцогч талуудыг хамруулан олон нийтэд мэдээлэл хийх	-Судалгааны дүнг нэгтгэн боловсруулж, олон улсын зөвлөх, яамны холбогдох ажилтнууд, мэргэжлийн холбоодын төлөөлөл, төслийн багийн хүрээнд тус тус хэлэлцүүлсэн. -Хуулийн төслийг хэлэлцүүлэх бүхий л шатанд холбогдох яам, газрууд, Засгийн газар, Байнгын хороонд хүргүүлсэн ерөнхий танилцуулгад хавсралт байдлаар хүргүүлсэн. -Органик ХАА-г хөгжүүлэхэд чиглэсэн загварын төсөл, дэмжих үйлчилгээ, зохицуулах арга хэмжээний төслийг боловсруулж, “Органик ХАА-г дэмжих” үндэсний хөтөлбөрийн төсөлд холбогдох санал тусгууллаа. -Гэрээ байгуулсан Монголын зөгийчдийн нийгэмлэг, Монголын чацаргана тариалагч, үйлдвэрлэгчдийн холбоо болон Хаан жимс ХХК, Гацуурт ХХК-иудтай гэрээнд заасны дагуу 2015 оны 9 сарын сүүлч 10 сарын эхний 7 хоногт үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, Чингисийн талбайд хийсэн хүнс үйлдвэрлэгчдийн хүндэтгэлийн параданд оролцсон. Энэ үзэсгэлэн ХХААЯ-наас зохион байгуулдаг “Намрын ногоон өдрүүд” нэгдсэн арга хэмжээний хүрээнд хийгдсэн бөгөөд 2015 онд “Монгол хүнс-органик хүнс” уриан дор зохион байгуулсан. -Органик хүнсний тухай хуулийн төслийн үзэл баримтлалын талаарх танилцуулгыг бэлтгэж, “Хүн ба хүнс 96/15 сэтгүүлд /№2 96-2015/ хэвлүүлсэн. -Органик ХАА-н чиглэлээр “Хүн ба хүнс” сэтгүүлийн тусгай дугаарыг 2015 оны 10 дугаар сард гаргаж, 1000 хувь хэвлүүлэн тараасан бөгөөд уг сэтгүүлд судалгааны ажлын гол үр дүнгээр 2 нийтлэл бичиж хэвлүүлсэн. <p style="text-align: right;">ХШҮ-100%</p>
2-р үр дүн: Органик бүтээгдэхүүнийг дэмжих, чадавхийг хөгжүүлэх үйлчилгээний заалт бүхий үндэсний хөтөлбөр боловсруулна.		
9	Үйл ажиллагаа 2.1. Органик ХАА-н салбарт чадавхийг хөгжүүлэх талаар Засгийн газар болон хувийн хэвшлийн хэмжээнд хэрэгцээ шаардлагыг тодорхойлох (Зохицуулалтын асуудлыг хамруулсан өртгийн сүлжээ)	Органик хүнс, хөдөө аж ахуйн Үндэсний анхдугаар чуулганыг Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын хурлын зааланд 2016 оны 10 дугаар сарын 12-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Чуулганд төрийн, төрийн бус, эрдэм шинжилгээ, сургалтын байгууллагууд, Олон улсын байгууллага, аж ахуйн нэгжийн нийт 150 гаруй төлөөлөл оролцов. <u>Чуулганаар хэлэлцсэн асуудлууд:</u> 1. Монгол улсад органик ХАА-г хөгжүүлэх боломж, тулгарч буй бэрхшээлийг хэлэлцэн, цаашдын арга замыг тодорхойлов. 2. Олон улсын Органик ХАА-н хөгжлийн төлөв, эрх зүйн зохицуулалтыг Монгол улсын нөхцөл байдалтай харьцуулан, оролцогчдод мэдээлэв. 3. Оролцооны баталгаажуулалтын байгуулагыг итгэмжлэх чиг үүрэг бүхий Үндэсний Органик Холбоог байгуулах талаар оролцогчдын саналыг нээлттэй сонсож, хэлэлцэв. 4. Органик үйлдвэрлэлийн зарчмыг Монгол улсын Хүнс хөдөө аж ахуйн салбарт хэвшүүлэх чиглэлээр шийдвэр гаргагчид, бодлого боловсруулагчид, судалгаа шинжилгээний байгууллагууд, үйлдвэрлэгчид, олон улсын байгууллагууд, төрийн бус байгууллагууд, хэрэглэгчдэд хандсан уриалгын төслийг хэлэлцэж, оролцогчдын саналыг тусгав. <u>Чуулганаас гарсан чиглэл, үр дүн:</u>

		<p>Уриалгыг холбогдох байгууллага, орон нутагт бичгээр хүргүүлэн, цахим мэдээллийн сүлжээгээр олон нийгэд мэдээлэв. Чуулганы үйл ажиллагааг жил бүр тогтмол зохион байгуулахаар шийдвэрлэв.</p> <p>“Global communities” ОУБ-ын EMIRGE хөтөлбөр, Монголын бэлчээр ашиглалтын нэгдсэн холбоо төрийн бус байгууллагаас органик сургалтыг хамтран зохион байгуулах боломжтой талаар албан ёсоор мэдэгдэв.</p> <p>Органик хүнс, хөдөө аж ахуйн хөгжлийг дэмжих төрийн бус байгууллагыг зохих хууль журмын дагуу байгуулж, оролцооны баталгаажуулалтын болон бусад чиглэлд хамтран ажиллахаар шийдвэрлэв.</p> <p>Аймаг, орон нутгийн ХХААГ-ын хүнсний асуудал хариуцсан мэргэжилтнүүд тухайн нутаг дэвсгэрт органик хүнс хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулах сонирхолтой аж ахуйн нэгж, иргэдийн судалгааг гаргаж, ХХААХҮЯ-д ирүүлэхээр тохиролцов.</p> <p style="text-align: right;">ХШҮ-50%</p>
10	<p>Үйл ажиллагаа 2.2. Эрх зүйн баримт бичиг боловсруулахад Засгийн газар, яамдад нь дэмжлэг туслалцаа үзүүлэх (Оролцооны баталгаажуулалтын систем-PGS, органик ХАА-н баталгаажуулалт, итгэмжлэл, татаас болон бусад)</p>	<p>- УИХ-ын БОХХААБХ-ны тус байнгын хорооны 2015.10.09-ний 08 дугаар тогтоолоор байгуулсан дэд ажлын хэсэг, тус байнгын хорооны гишүүдтэй уулзалт зохион байгуулж, органик хүнсний үйлдвэрлэл, баталгаажуулалтын талаар олон улсын зөвлөх, ОХААОУХХ /ФОАМ/-ны ерөнхийлөгч асан Р. Гуннар мэдээлэл хийсэн.</p> <p>-Засгийн газрын 2014 оны 11-р сарын 21-ний өдрийн хуралдааны 59 дүгээр тэмдэглэлээр “Органик хүнсний тухай” хуулийн үзэл баримтлалын төслийг хэлэлцэн дэмжээд, Хууль зүйн сайдын 2015 оны 01-р сарын 20-ны өдрийн 1/230 дугаар албан бичгээр “Органик хүнсний тухай” хуулийн үзэл баримтлалыг батлуулсан.</p> <p>-ХЗЯ-ны 2015 оны 06-р сарын 04-ний өдрийн 1/2142 тоот албан бичгээр Органик хүнсний тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхийг зөвшөөрсөний дагуу 2015 оны 06-р сарын 10-ны өдөр УИХ-д өргөн барьж, 2016 оны 02-р сарын 04-ний өдрийн УИХ-ын чуулганаар хэлэлцүүлсэн.</p> <p>- 2016 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн УИХ-ын чуулганы хуралдаанаас Органик хүнсний тухай хуулийг баталсан.</p> <p>-Төрөөс ХХАА-н талаар баримтлах бодлого-2025 он, 6.2.7-д, Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Үзэл Баримтлал- 2030, 2.1-д, Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2.20-д органик хүнс хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх тухай зорилт, заалтыг тус тус суулгасан.</p> <p>-Органик хүнсний үйлдвэрлэлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулсан боловч төсвийн хүндрэлээс шалтгаалан хэлэлцэж, батлан, хэрэгжүүлэх боломжгүй гэж үзсэн болно.</p> <p>-2016 оны 9 дүгээр сараас эхлэн “Органик газар тариалангийн журмын төсөл”, “Органик мал аж ахуйн журмын төсөл”, “Органик зөгийн аж ахуйн журмын төсөл”, “Органик хүнсийг боловсруулахад баримтлах журмын төсөл”, “Органик үйлдвэрлэлд хэрэглэхийг зөвшөөрсөн бодисын жагсаалтын төсөл”, “Органик хүнсийг боловсруулахад ашиглах хүнсний нэмэлт болон туслах бодис, тоног төхөөрөмжийн ариутгал, халдваргүйжүүлэлтэд хэрэглэх бодисын жагсаалтын төсөл”, “Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журмын төсөл”, “Органик хүнсний орцын найрлага тооцох аргачлалын төсөл”, “Органик хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан үйлдвэрлэгч, хэрэглэгч болон бусад тал хамтран баталгаажуулахад тавигдах шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журмын төсөл” зэрэг нийт 7 журам 1 аргачлалын төслүүдийг боловсруулж, холбогдох мэргэжилтнүүдээс санал авах, www.mofa.gov.mn цахим хуудасны “төсөл, хэлэлцүүлэг” хэсэгт байршуулж, Захиргааны Ерөнхий хуулийн холбогдох шаардлагад нийцүүлэн цахимаар санал авах,</p>

		<p>хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж байна.</p> <p>2017 оны 3-4 сард ОХААОУХХ /IFOAM/-ны ерөнхийлөгч асан Р. Гуннарыг урьж, журам, аргачлалын төслүүдэд техникийн зөвлөгөө авахаар төлөвлөсөн.</p> <p style="text-align: right;">ХШҮ-90%</p>
11	<p>Үйл ажиллагаа 2.3. Дотоодын зах зээлийн PGS болон хөндлөнгийн баталгаажуулалт, экспорт, баталгаажуулалтын бусад боломжийн талаар семинар зохион байгуулах;</p>	<p>-2014 оны 09-р сарын 09-ний өдөр Төслийн техникийн зөвлөх Кевин Галлахертай хамтран Органик хүнсний талаарх ойлголт, органик бүтээгдэхүүнд тавих шаардлага, үйлдвэрлэлийн зохистой дадал, органик хүнсний маркетинг, баталгаажуулалтын талаар үйлдвэрлэгч, фермер, өрхийн аж ахуй эрхлэгч, төрийн бус байгууллагын төлөөлөл зэрэг 40 хүнийг хамруулан сургалт хийсэн.</p> <p>- 2015 оны 3-р сарын 31-ний өдөр Монгол Улсад 2015 оны 3-р сарын 30-ны өдрөөс 4-р сарын 08-ны өдрүүдэд ажилласан Төслийн олон улсын зөвлөх Онг Кунг Вайтай хамтран “Баталгаажуулалтын ач холбогдол, баталгаажуулалтын үйл явц” сэдэвт сургалт-хэлэлцүүлгийг органик чиглэлээр үйлдвэрлэл эрхлэх хүсэлт гаргасан фермерүүд, үйлдвэрлэгчид болон мэргэжлийн холбоодын төлөөлөл 30 гаруй хүнийг хамруулан зохион байгуулсан.</p> <p>-2015 оны 4-р сарын 01-ний өдөр “Органик үйлдвэрлэлийн оролцооны баталгаажилтын тогтолцоо /PGS/, дотоод хяналтын тогтолцоо” сэдэвт сургалтыг МҮХАҮТ-ын “Органик Монгол” хөтөлбөрт оролцогчид болон органик чиглэлээр үйлдвэрлэл эрхлэх хүсэлт гаргасан фермерүүд, үйлдвэрлэгчид, мэргэжлийн холбоодын төлөөлөл 40 гаруй хүнийг хамруулан зохион байгуулсан.</p> <p>-2015 оны 8-р сарын 17-ны өдөр “Органик хүнсний ногооны аж ахуй эрхлэх зохистой дадлын үндэс ба баталгаажуулалтын тогтолцоо” сэдэвт сургалтыг төвийн бүсийн хүлэмжийн аж ахуй эрхлэгч 30 гаруй аж ахуй нэгж, фермерүүдийн төлөөллийг хамруулан зохион байгуулсан.</p> <p>-2016 оны 10 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд “Оролцооны баталгаажуулалтын олон улсын 2 өдрийн сургалт”-ыг батлагдсан хөтөлбөрийн дагуу Азийн Бүтээмжийн байгууллага, Монголын бүтээмжийн төвтэй хамтран зохион байгуулсан бөгөөд хөдөө орон нутаг болон нийслэлийн 150 гаруй үйлдвэрлэгчид оролцов. ХХААХҮЯ-ны ТНБД Л.Баяртулга, НҮБ-ын ХХААБ-ын Монгол дахь Шадар суурин төлөөлөгч Кевин Д. Галлахер, АББ-ын эксперт Konrad Hauptfliesch нар үг хэлж, илтгэл тавьж, сургалтыг чиглүүлж, хөтөлсөн болно. Амжилттай оролцсон хүмүүст гэрчилгээ олгов.</p> <p>-Органик хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйл нь бүхэлдээ баталгаажуулалтын байгууллага, органик үйлдвэрлэл болон хүнсний баталгаажуулалт, бүртгэлийн асуудлыг зохицуулж байгаа бөгөөд Оролцооны баталгаажуулалтын байгууллагад тавигдах шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журмын төслийг боловсруулан цахим болон танхимын хэлэлцүүлгийг явуулж байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p>
12	<p>Үйл ажиллагаа 2.4. Олон улсын итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагын дэмжлэгтэйгээр “Шилжилгийн үеийн Монгол органик хүнс” эсвэл “Монгол органик хүнс” брэндийн шаардлагыг хангаж болохуйц нэг болон түүнээс дээш хэд хэдэн төрлийн бүтээгдэхүүн (өртгийн сүлжээ)-ий талаар судалгаа, зохицуулалт хийх (Тухайлбал: чацаргана, мах, төмс, улаан буудай, лууван, рапсын үр,</p>	<p>-Хэрэглэгчийн болон байгальд ээлтэй, органик фермийн өнөөгийн байдлын үнэлгээ, зах зээлийн нөөц бололцооны судалгааны дүнд үндэслэн “Шилжилгийн үеийн Монгол органик хүнс” эсвэл “Монгол органик хүнс” брэндийн шаардлагыг хангаж болохуйц чацаргана, зөгийн бал, төмс зэрэг 3 төрлийн бүтээгдэхүүний сонголт хийсэн.</p> <p>-Дээрх судалгааны дүнд үндэслэн органик ХАА-г хөгжүүлэх загвар гаргасан.</p> <p>-Олон улсын шинжээч Он Кун Вайтай хамтран Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн, Цагааннуур, Алтанбулаг сумдад байрлах Хаан жимс ХХК-ийн чацаргана, Гацуурт ХХК-ийн төмс, Товхон жимс ХХК-ийн чацарганын талбайтай танилцаж, органик үйлдвэрлэл эрхлэх боломжийн урьдчилсан үнэлгээ хийлгэж, зөвлөлгөө</p>

	зөгийн бал, цай, ургамлын төрлийн бүтээгдэхүүн г.м)	<p>өгүүлэх ажлыг зохион байгуулсан.</p> <p>-“Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журмын төсөл”-ийг боловсруулж, “Органик Монгол” тэмдэг, тэмдэглэгээний загвар, brand book-ийг боловсруулах ажил хийгдэж байна.</p> <p>- Органик хүнсийг баталгаажуулах 3 түвшний байгууллага Монгол улсад үйл ажиллагаа явуулах эрхтэй байхаар Органик хүнсий тухай хуульд зохицуулалт хийсэн. Үүнд: 1/СХЗГ-аас итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага 2/Монгол Улсад бүртгүүлсэн, олон улсын итгэмжлэлтэй баталгаажуулалтын байгууллага 3/ харилцан итгэлцэлд тулгуурлан үйлдвэрлэгч, хэрэглэгч болон бусад талууд хамтран баталгаажуулах оролцооны баталгаажуулалтын байгууллага болно.</p> <p style="text-align: right;">ХШҮ-50%</p>
3-р үр дүнгийн хүрээнд: Төсөлд оролцогч талуудын мэдлэг дээшилж, органик фермийн аж ахуй байгуулагдан, органик бүтээгдэхүүний маркетинг сурталчилгаа хийгдсэн байна.		
13	Үйл ажиллагаа 3.1. Уламжлалт мэдлэг болон орчин үеийн дэвшлийг органик салбарт нэвтрүүлэх талаарх сургалтыг сонирхсон бодлого тодорхойлогчдод зориулан зохион байгуулах, үйлдвэрлэлийн болон маркетингийн амжилттай хэрэгжиж буй газруудад танилцах аялал зохион байгуулах	<p>-Органик ХАА-н талаарх уулзалт-хэлэлцүүлгийг УИХ-ын зарим гишүүн, УИХ-ын БОХХААБХ, ХХААЯ, СХЗГ, МХЕГ, СХЗГ, МҮХАҮТ-ын Органик Монгол хөтөлбөр, Фермерүүдийн холбоо, ОХААЭХолбоо, Монголын Зөгийчдийн нийгэмлэгийн төлөөллийг оролцуулан Засгийн газрын ордонд 2015 оны 12 сард зохион байгуулсан.</p> <p>-“Органик бүтээгдэхүүний баталгаажуулалтын тогтолцоо ба органик бордоо бэлтгэх технологийн үзүүлэх сургалт”-ыг 2015 оны 08 дугаар сарын 12-13-ны өдөр Хэнтий аймагт тус аймгийн 11 сумаас 35 аж ахуй нэгж, фермерүүдийн төлөөллийг хамруулан зохион байгуулав.</p> <p>- “Монгол хүнс-Органик хүнс” анхны зангиагүй уулзалтыг “Намрын ногоон өдрүүд” нэгдсэн арга хэмжээний үеэр буюу 2015 оны 09 сард Төрийн болон төрийн бус байгууллага, үйлдвэрлэгч, фермерүүдийг хамруулан зохион байгуулж, хамтран ажиллах талаар санал солилцсон.</p> <p>-2016 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр “Намрын ногоон өдрүүд” арга хэмжээний үеэр “Монголын Органик ХАА-г дэмжих төсөл”- ТСР/MON/3503-ийн хаалтын үйл ажиллагааг зохион байгуулж, органик хүнс хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр идэвхтэй хамтран ажилласан аж ахуйн нэгж байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг шагнаж урамшуулав. Мөн төслийн хэтийн төлвийн талаар олон улсын байгууллагын төлөөлөл болон үндэсний үйлдвэрлэгчид санал солилцов. .</p> <p>- Монголын Хүнсчдийн холбооноос эрхлэн гаргадаг Хүн ба Хүнс сэтгүүлийн 2016 оны 3-р улирлын 101 дугаарт Органик хүнсий тухай хуулийн танилцуулга, зурагт хуудсыг хэвлүүлэв.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p>
14	Үйл ажиллагаа 3.2. Дадлага-туршлагын хүрээнд Органик фермерийн аж ахуй, техник, маркетингийн туршлагын тухай “үйлдвэрлэл, маркетингийн сургалт”-ыг холбогдох байгууллагууд, МҮХАҮТ болон фермерүүдэд зориулан зохион байгуулах.	<p>-2015 оны 10 сард Хүнсний боловсруулах үйлдвэрлэл эрхлэгч нарт зориулсан “Органик хүнсний үйлдвэрлэл” сэдэвт сургалтыг 2015 оны 10 сард ХХААЯ дээр зохион байгуулж, хүнсний 30-аад үйлдвэрлэгчид оролцож, санал солилцов.</p> <p>-Зөгийчдийн нийгэмлэг, Дэлхийн Зөн ОУ-ын байгууллагаас хамтран 2015 оны 3 сард, ШУТИС-ийн Хүнсний аюулгүй байдлын мэргэжлийн ангийн 35 оюутанд 2015 оны 5-р сард, Зөгийчдийн нийгэмлэг, ХААИС-ийн 2015 оны 8 сард хамтран зохион байгуулсан 120 зөгийчин оролцсон сургалт-семинарт тус тус оролцож, органик хүнсний тухай ойлголтын талаар мэдээлэл хийж хэлэлцүүлсэн.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p>
15	Үйл ажиллагаа 3.3. Бүтээгдэхүүнийг нь органик үйлдвэрлэлийн аргад шилжүүлэх хоёр болон түүнээс дээш хүнсний үйлдвэрлэгчийг сонгон шалгаруулж техник болон	<p>-Бүтээгдэхүүнээ органик хүнсээр баталгаажуулах сайн дурын хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, холбооноос санал авч нэгтгэн, санал солилцсон. Аж ахуйнуудаас ирүүлсэн саналыг нэгтгэн 2015 оны 2 сард НҮБ-ын ХХААБ-д хүргүүлсэн.</p> <p>-Баталгаажуулалтад хамрагдахаар санал ирүүлсэн аж ахуй нэгжид урьдчилсан үнэлгээ хийх ажлын хөтөлбөр боловсруулсан.</p>

	санхүүгийн дэмжлэг туслалцаа үзүүлэх	<p>-Төслийн баг пестицид илрүүлэгч аппаратын үнийн судалгаа хийж, захиалах, нийлүүлэх арга хэмжээ авахаар ажиллаж байна. Органик бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шилжихээр олон улсад имтгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагатай ажиллаж байгаа шилжилтийн үеийн аж ахуйн нэгж байхгүй учраас санхүүгийн дэмжлэгийг үзүүлээгүй болно. Энэ асуудлыг Азийн хөгжлийн банкны “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил” төсөл болон ЕХ-ны "Монголд ажлын байрыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх" Support to Employment Creation in Mongolia" SECiM төслийн хүрээнд шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн.</p> <p style="text-align: right;">ХШҮ-30%</p>
16	<p>Үйл ажиллагаа 3.4. Судлаачид болон үндэсний холбогдох байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох асуудлыг дэмжсэн сургалт, уулзалт зохион байгуулах.</p>	<p>Органик ХАА-н бүтээгдэхүүн, түүхий эдийг баталгаажуулахад тавигдах шаардлагын төслийг боловсруулж, Монголын зөгийчдийн нийгэмлэг, Монголын чацаргана тариалагч, үйлдвэрлэгчдийн холбоо, Монголын хөдөөг шинэчлэх фермерүүдийн холбоо, МҮХАҮТ-ын Органик Монгол хөтөлбөр, Газар шим ХХК, ОХААЭХолбоо, Монгол сонгино судлаач, зэрэг байгууллага, судлаач нартай уулзалтуудыг 2-3 удаа зохион байгуулж, байгууллага бүртэй тухайн байгууллага дээр нь болон яаман дээр тусгайлан уулзалт хийж, мэдээлэл солилцох, хамтран ажиллах талаар санал солилцсон.</p> <p>-Эхний уулзалт 2014.09 сар: Монголын зөгийчдийн нийгэмлэг, Монголын чацаргана тариалагч, үйлдвэрлэгчдийн холбоо, Монголын хөдөөг шинэчлэх фермерүүдийн холбоо, Монгол төмс хөтөлбөр, ШУТИС-ийн ҮТС-ийн дэргэдэх “Хүнс судлалын эрдэм шинжилгээний төв” лаборатори, Хаан жимс ХХК, Газар шим ХХК, МҮХАҮТ-ын Органик Монгол хөтөлбөр, Монгол сонгино судлаач нартай тус бүрт нь уулзалт хийж, санал солилцсон.</p> <p>-2014.09-10 сард: Газар шим ХХК-ийн жимс, ногоо боловсруулах үйлдвэр, артишок тариалалтын талбай болон ШУТИС-ийн ҮТС-ийн дэргэдэх “Хүнс судлалын эрдэм шинжилгээний төв” лабораторийн үйл ажиллагаатай танилцаж, санал солилцсон.</p> <p>-2015.01 сард: ХХААЯ-ны ХҮБХЗГ-ын даргын өрөөнд Монголын Зөгийн нийгэмлэг, Монголын чацаргана тариалагч, үйлдвэрлэгчдийн холбоо, Хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн холбоо, Монголын органик хөдөө аж ахуй эрхлэгчдийн холбоо, МҮХАҮТ-ын Органик Монгол хөтөлбөрийн төлөөлөлтэй уулзаж, хамтран ажиллах чиглэлийг ярилцаж тохирсон бөгөөд Гацуурт ХХК-ийн удирдлагуудтай уулзаж, органик төмс тариалах талаар санал солилцож, хамтран ажиллах талаар харилцан тохирсон.</p> <p>-2015.02 сард: Дээрх мэргэжлийн холбоодуудтай хамтран ажиллах санамж бичиг, аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан ажиллаж эхэлсэн. Эдгээр байгууллагуудтай цахим хэлбэрээр болон биечлэн уулзаж зөвлөгөө өгч ажиллаж байна.</p> <p>-“Органик ХАА-г хөгжүүлэх” төслийн хүрээнд Монгол Улсад энэ оны 3 дугаар сарын 30-ны өдрөөс 4 сарын 08-ны өдрүүдэд ажилласан олон улсын зөвлөхийг МХЕГ, СХЗГ-ын үйл ажиллагаатай танилцуулж, органик хүнсээ баталгаажуулах хүсэлт гаргаж, гэрээ байгуулсан Сэлэнгэ аймагт байршилтай чацаргана, төмс тариалагч аж ахуйн нэгжүүдийн болон худалдаа явуулж буй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай танилцуулж, органик хүнсийг баталгаажуулах чиглэлээр цаашид авах арга хэмжээний талаар зөвлөмж, арга зүйн зөвлөгөө өгч, сургалтууд зохион байгуулсан.</p> <p>-2016 оны 07-10 сард: НҮБ-ын ХХААБ-ын санхүүжилтээр “Органик хөдөө аж ахуйн гарын авлага”, “Органик хүнс үйлдвэрлэлд тавигдах шаардлагууд” номыг тус бүр 500 хувь, Органик хүнсний тухай хуулийн англи, монгол хэл дээрх гарын авлага, хуулийн тухай 5 төрлийн зурагт хуудсыг тус бүр 2000 хувийг хэвлүүлж, олон нийтэд түгээв.</p> <p>Органик хүнсний тухай хуулийн хэрэгжилтийг хангах, органик</p>

		хүнсний бүтээгдэхүүний ач тусыг нийгэмд таниулан сурталчлах, баталгаажсан органик монгол бүтээгдэхүүний дотоодын худалдааг идэвхжүүлэх зорилгоор “Номин Тав Трейд” ХХК, “Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим Төрийн бус байгууллагууд хамтран ажиллах Харилцан ойлголцлын санамж бичгийг зурж, органик түншлэлийн өдөрлөгийг зохион байгуулав. Органик хүнсний тухай хуулийг сурталчилах сурталчилгааг 2016 оны 11 сарын 26-ны өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд 3 удаагийн давталттайгаар UBS, MN 25, NTV, TV9, EDU, Asian box, Movie box сувгаар цацав. ХШҮ-100%
17	Үйл ажиллагаа 3.5. PGS-ийн органик фермерүүдийн загвар байгууллагыг зохион байгуулах	2016 оны 10 дугаар сард зохион байгуулагдсан Органик хүнс, хөдөө аж ахуйн Үндэсний анхдугаар чуулганы үеэр Монгол улсад органик ХАА-г хөгжүүлэх боломж, тулгарч буй бэрхшээлийг хэлэлцэн, Оролцооны баталгаажуулалтын байгууллагыг итгэмжлэх чиг үүрэг бүхий Үндэсний Органик Холбоог байгуулах талаар оролцогчдын саналыг нээлттэй сонсож, “Global communities” ОУБ-ын EMIRGE хөтөлбөр, Монголын бэлчээр ашиглалтын нэгдсэн холбоо төрийн бус байгууллага, АДРА МОНГОЛ олон улсын байгууллагаас Оролцооны баталгаажуулалтын байгууллагыг байгуулах, хөдөө орон нутгийн үйлдвэрлэгчдийг хамруулан хамтран ажиллах, Үндэсний Органик Холбоог зохих хууль журмын дагуу байгуулахад идэвхтэй оролцох талаар албан ёсоор мэдэгдэв. Оролцооны баталгаажуулалтын байгууллагад тавигдах шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журмын төслийг Органик ХАА-н хөдөлгөөнүүдийн олон улсын Холбооноос тавигдаж буй үндсэн шаардлага, Монгол улсын онцлог байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр боловсруулж, www.mofa.gov.mn цахим хуудсын төсөл хэлэлцүүлэг буланд санал авахаар тавьсан. ХШҮ-50%
18	Үйл ажиллагаа 3.6. Органик фермерүүдийн байгууллагын загварын талаар сургалт зохион байгуулах ба тэдгээрийг PGS схемтэй холбох ажлыг зохион байгуулах	-Монголын чацаргана тариалагч, үйлдвэрлэгчдийн холбоотой хамтарч “Органик бүтээгдэхүүний баталгаажуулалтын тогтолцоо ба органик бордоо бэлтгэх технологийн сургалт”-ыг 2015 оны 06 дугаар сард зохион байгуулав. - “Органик хүнс, хөдөө аж ахуй, баталгаажуулалт” сэдэвт уулзалтыг олон улсын зөвлөх R.Gunnar-тай хамтран газар тариалан, зөгий, мал аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл зэрэг чиглэлийн төлөөллийг оролцуулан 4 удаагийн нээлттэй хэлэлцүүлэг хэлбэрээр 2015 оны 12 сард ХХААЯ дээр зохион байгууллаа. -Зөгийчдийн нийгэмлэгээс зохион байгуулсан зөгийн мэргэжилтнүүдийн уулзалтанд PGS тогтолцооны талаар ойлголт өгөх мэдээлэл хийсэн. -2016 оны 10 дугаар сард Азийн бүтээмжийн байгууллагатай хамтран PGS-ийн талаар үндсэн ойлголтыг өгөх Оролцооны баталгаажуулалтын олон улсын 2 өдрийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд 150 гаруй хүн оролцсон. Оролцооны идэвхийг харгалзан үзээд гэрчилгээ олгосон болно. Сургалтын давуу тал нь хөдөө орон нутгийн ХХАГ-ын хүнсний асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг албан ёсоор оролцуулснаар PGS тогтолцоог хамгийн их бүрэлдэх магадлалтай орон нутагт мэдээлэл очих боломж бүрдсэн болно. ХШҮ-50%
19	Үйл ажиллагаа 3.7. Практик дадлага эзэмшүүлэх зорилгоор фермерүүдийн харилцан солилцох үйл ажиллагааг зохион байгуулах	2015 оны 08 дугаар сарын 19-20-н өдрүүдэд Дархан, Сэлэнгийн бүсийн органик хөдөө аж ахуйн эрхлэгч аж ахуйн нэгж, фермер, өрхийн тариаланчдыг хамруулан туршлага солилцох үзүүлэх сургалт зохион байгуулсан.Монголын зөгийчдийн нийгэмлэгээс “Зөгийн аж ахуйн салбарын нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх” төсөл, PGS-ийн загварыг байгуулахаар хамтран ажиллаж байна. ХШҮ-50%
20	Үйл ажиллагаа 3.8. Дотоодын	Япон, БНСУ-ын Органик Хөдөө, аж ахуйн үйл ажиллагаа,

	органик фермерүүдийг дэмжих зорилгоор олон улсын хэмжээнд зохиогдох органик манлайлал сургалт болон семинарт оролцох	органик хүнсний сүлжээ, маркетинг, хэрэглэгчдэд хандсан зохион байгуулалтын арга хэлбэр, салбарын яам, баталгаажуулалтын байгууллагын үйл ажиллагаа, ялгаа, органик бүтээгдэхүүнийг баталгаажуулж буй хэлбэрүүд, дэвшилтэт арга ажиллагаа, туршлага, органик хүнсний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй холбоодын үйл ажиллагааны онцлогыг судалж танилцсан. ХШҮ-90%
21	Үйл ажиллагаа 3.9. Органик ХАА-н техник технологи, гэрчилгээжүүлэлтийн талаар телевизийн хөтөлбөр бэлтгэж цацах	-Органик хүнсний талаарх нэвтрүүлгийг ХХААЯ-наас зохион байгуулдаг “Намрын ногоон өдрүүд” нэгдсэн арга хэмжээний үеэр зураг авалт хийж, бэлтгэсэн. -Нэвтрүүлгийн хөтөлбөрт органик үйлдвэрлэл, хүнсээ баталгаажуулах талаар гэрээ байгуулан органик чиглэлээр ажиллаж буй аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаа, Органик хүнс-Монгол хүнс сэдэвт үзэсгэлэн-худалдаа, 2015 оны 08 сарын 19-20-ны өдрүүдэд хийсэн туршлага солилцох сургалт зэргийг оролцуулан Монголын органик хөдөө аж ахуй сэдэвт телевизийн нэвтрүүлгийн зураг авалтыг хийсэн. Нэвтрүүлгийг МҮХАҮТ-ын “Органик Монгол” хөтөлбөр бэлтгэж, нэвтрүүлгийн хөтөлбөрийн төсөл, саналыг Монгол Улс дахь НҮБ-ын ХХААБ-ын Шадар суурин төлөөлөгчийн газар цахимаар хүргүүлсэн. Мөн Монгол улсын органик хөдөө аж ахуйн хөгжлийн боломжууд, Органик ХАА-н давуу тал, органик хөдөө аж ахуйн хууль эрх зүйн орчин, органик хөдөө аж ахуйг хөгжүүлэх төслийн хүрээнд хамтран ажилласан талуудын нэгдсэн зорилго үйл ажиллагааны тухай товч мэдээлэл хүргэх, сурталчлах зорилго бүхий TV нэвтрүүлгийг батлагдсан хөтөлбөрийн дагуу 2016 оны 10 сард дахин бэлтгэсэн. ХШҮ-50%
4-р үр дүнгийн хүрээнд: Олон улсын хэмжээнд баталгаажих “Монгол органик хүнс”-ийг бий болгоно.		
22	Үйл ажиллагаа 4.1: Дээрх 1 болон 2 дугаар үр дүнгийн дагуу “Монголын органик хүнс” брэндийн дор борлуулах, шошготой байх бүтээгдэхүүнийг шалгах зорилгоор үндэсний хэмжээний хоёр болон түүнээс дээш гэрчилгээжүүлэлтийн байгууллагын чадавхийг дээшлүүлэх	-СХЗГ-тай хамтран 2015 оны 4-р сарын 06-11-ний өдрүүдэд "Органик хүнсний бүтээгдэхүүний баталгаажуулалтын шинжээчийг бэлтгэх" сургалтыг зохион байгуулж, органик хүнсний баталгаажуулалтын чиглэлээр орон тооны бус шинжээчийн эрхийг 25 ажилтанд олгосон. -Органик хүнсний баталгаажуулалтын шинжээч нарт гэрчилгээ гардуулах арга хэмжээг зохион байгуулж, Төв аймгийн Архустад үзүүлэх сургалтыг 2015 оны 5-р сарын 29-ний өдөр хийсэн. ХШҮ-30%
23	Үйл ажиллагаа 4.2: Монголд үйлдвэрлэсэн органик бүтээгдэхүүний бүртгэлийн болон мэдээллийн сүлжээний системийн хөгжилд техникийн туслалцаа үзүүлэх	-Органик ХАА-н талаарх Facebook.com/mongolorganic www.facebook.com/mongolorganic нээн ажиллуулж, ХХААЯ-ны ASU, веб сайттай холбох арга хэмжээ авсан. Мөн органик үйлдвэрлэлийн баталгаажуулалтын орон тооны бус шинжээчдийн болон ШУТИС-ийн оюутануудын органик хүнсний facebookтэй холбосон. -“Органик ХАА-н үйлдвэрлэлд тавигдах шаардлага, мөрдөх анхан шатны бүртгэл” гарын авлагын төсөл боловсруулсан. - Органик хүнсний тухай хуульд тусгагдсаны дагуу МХЕГ-ын Хүнсний аюулгүй байдлын хяналтын удирдлагын системтэй холбох боломжтой органик хүнсний мэдээлэл, бүртгэлийн сангийн алгоритм (архитектур, загвар), хэрэглэгчдэд зориулсан цахим хуудсын программыг боловсруулж, гүйцэтгэх ажлын даалгаврын төслийг боловсруулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. ХШҮ-30%
24	Үйл ажиллагаа 4.3: Монгол Улсын Засгийн газрын санал болгосноор органик хүнсний эвшөөрөгдсөн бодисын талаар экспертын дүгнэлт, дүн шинжилгээ	-“Монгол Улсад хэрэглэх ургамал хамгаалах биологийн гаралтай бодис, бордоог турших, бүртгэх, түүнийг хэрэглэх журам”-ын төслийн 1.6 дахь заалтад “Мал аж ахуй, газар тариалангийн органик үйлдвэрлэлд болон органик хүнсний боловсруулах үйлдвэрлэлд Органик хүнсний талаарх үндэсний стандартад заасан бодисыг тус стандартад заасны дагуу хэрэглэнэ.” гэж

		тусгасан. - Органик хүнсний тухай хуулийн төслийн 8.3 дахь заалтад “Органик хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх болон хүнс үйлдвэрлэхэд баримтлах журам, хэрэглэх бодисын жагсаалтыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасны дагуу журмын төслийг боловсруулж байна. ХШҮ-30%																		
25	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Ололт - Эх орны байгальд ээлтэй, газар тариалангийн аж ахуйн өнөөгийн байдлын талаарх судалгаа, хэрэглэгчийн судалгаа, Япон, БНСУ-ын органик хүнсний зах зээлийн судалгааг баримтын болон анхдагч эх үүсвэрийн аргад тулгуурлан анх удаа гүйцэтгэсэн. -СХЗГ-тай хамтран "Органик хүнсний бүтээгдэхүүний баталгаажуулалтын шинжээчийг бэлтгэх" танхимын болон үзүүлэх сургалтыг зохион байгуулж, органик хүнсний баталгаажуулалтын чиглэлээр орон тооны бус шинжээчийн эрхийг 25 ажилтанд олгосон нь органик хүнс, хөдөө аж ахуйн чиглэлийн хүний нөөцийг бэлтгэх суурийг тавьж, чадавхийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулсан байна.</p> <p>Дутагдал Зарим тохиолдолд биелэхэд хугацаа нилээн шаардах үйл ажиллагааг төлөвлөсөн байсан тул нөхцөл байдлыг бодитой үнэлэн, явцын дунд өөрчлөх, дахиж төлөвлөх, хэрэгжилтийг хангах шаардлага зайлшгүй тулгарсан.</p> <p>Анхаарах асуудал -Органик хүнсний тухай хуулийг дагалдан гарах дүрэм журмын төслүүдийг цахим болон танхимын түвшинд яаралтай хэлэлцэж, батлах -Органик бүтээгдэхүүнийг баталгаажуулах эрх бүхий байгууллагыг чадавхижуулах -Органик бүтээгдэхүүний зах зээл, маркетингийн хүрээг хууль дүрэм журамд нийцүүлэн тодорхойлох -Органик ХХАА-г хөгжүүлэх чиглэлээр олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээг авах нь зүйтэй.</p>																		
	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ																			
	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	<table border="1"> <thead> <tr> <th colspan="6">Үйл ажилагааны хэрэгжилт, %</th> </tr> <tr> <th>Үр дүн</th> <th>1</th> <th>2</th> <th>3</th> <th>4</th> <th>Дундаж</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Биелэлт</td> <td>75,0</td> <td>77,5</td> <td>66,7</td> <td>36,7</td> <td>64.0</td> </tr> </tbody> </table>	Үйл ажилагааны хэрэгжилт, %						Үр дүн	1	2	3	4	Дундаж	Биелэлт	75,0	77,5	66,7	36,7	64.0
Үйл ажилагааны хэрэгжилт, %																				
Үр дүн	1	2	3	4	Дундаж															
Биелэлт	75,0	77,5	66,7	36,7	64.0															
	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	<table border="1"> <thead> <tr> <th colspan="6">Нэгдсэн үнэлгээ</th> </tr> <tr> <th colspan="6">....., %</th> </tr> </thead> <tbody> <tr> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table>	Нэгдсэн үнэлгээ					, %											
Нэгдсэн үнэлгээ																				
....., %																				